# Бат бөх суурь






4. Гатал гэж хэлснээр гүн усыг туулах цагт
Гай зовлонгийн голд чамайг живүүлэлгүй,
Туйлдсан үед чинь Би хамт байж адисална.
Чамайг цэвэршүүлнэ, чамайг цэвэршүүлнэ,
Чамайг зовлон шаналал чинь цэвэршүүлнэ.

5. Бэрхшээл зовлонгийн гал замд чинь дүрэлзэхэд
Би чамд ач ивээлээ харамгүй өгнө.
Дүрэлзэх галын дөл чамайг гэмтээхгүй,
Алт цэвэршүүлэх мэт, алт цэвэршүүлэх мэт,
Алт цэвэршүүлэх мэт ариусгах болно.

6. Ард түмэн минь насан өндөр болсон авч
Агуу хайр минь мөнхийн, хувиршгүйг мэднэ.
Санчигны үс нь бууралтах тэрхүү цагт
Хурга тэврэх мэт Би, хурга тэврэх мэт Би,
Хурга тэврэх мэт Би тэднийг тэвэрнэ.

7. Авралын төлөө Есүст итгэж найдсан
Аль ч хүнийг Би дайсных нь гарт орхихгүй.
Там итгэлийг нь сулруулахыг оролдсон ч
Би хэзээ ч орхихгүй, Би хэзээ ч орхихгүй,
Би хэзээ ч орхихгүй, түүнийг орхихгүй.

*Үг:* Робэрт Кийний үгийг авч ашиглав. Ойролцоогоор 1787 он.
Энэ дуулал 1835 оны Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм анхны дуулалд орсон байжээ.
*Ая:* Ж.Эллисийн аяыг авч ашиглав. Ойролцоогоор 1839 он.

Исаиа 41:10; 43:2–5
Хиламан 5:12